



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/255

Алтай хот

**Өндөржүүлсэн бэлэн байдлын
хугацааг сунгаж зохион байгуулалтын
арга хэмжээ авах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 154 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 33 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн хугацааг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.

2. "Алтайн хүдэр" ХХК-ийн хүдрийн уурхайд коронавирусын тохиолдол бүртгэгдэж "Улаан түвшин"-д шилжсэнтэй холбогдуулан тус газрын үйл ажиллагааг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд бүрэн зогсоосугай.

3. "Алтайн хүдэр" ХХК-ийг мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах ажлын хэсгийг хавсралтаар баталж, үйл ажиллагаатай холбоотой гарах зардлыг "Алтайн хүдэр" ХХК-аар гаргуулж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т даалгасугай.

4. Есөнбулаг сумын нийтийн хоол үйлдвэрлэлийн газруудын үйл ажиллагааг 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд бүрэн зогсоож аймгийн Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т даалгасугай.

5. Сум орон нутагт гарч байгаа халдварын голомтыг цомхотгох, хариу арга хэмжээ авч, тандалт судалгаа хийж, холбогдох мэргэжлийн байгууллагуудаас заавар зөвлөгөө аван, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2011 оны
06 дугаар сарын 14-ны өдрийн 145 дугаар
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Д.Отгонбаяр	-(аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүн:	З.Баттулга	-(Онцгой байдлын газрын дарга, хурандаа)
	Н.Эрдэнэ-Очир	-(Цагдаагийн газрын дарга, хурандаа)
	Ц.Туяа	-(Эрүүл мэндийн газрын дарга)
	Н.Сумъяабазар	-(Мэргэжлийн хяналтын газрын дарга)
	Д.Буяхишиг	-(Цээл сумын Засаг дарга)
Нарийн бичиг:	Н.Батсайхан	-(Зооноз өвчин судлалын төвийн дарга)

__оОо__